## I- Энэ түүхийг унш

### Наргианч сар

Гэрийнхээ урд охин хүү хоёр бөмбөгөөр тоглож байна.
Хэний бөмбөг шидэх ээлж вэ?
- Минийх !
- Үгүй, минийх !

Тэр хоёр ийнхүү маргалдаж эхлэх хооронд улаан хөх өнгийн бөмбөг өнхөрч холдов гэнэ.
Бөмбөг дээшээ моддын дээгүүр тэнгэрт хөөрч саранд тулж очоол мөргөж унагав гэнэ.
Сар газарт унаж бөмбөгтэй цуг ойж эхлэв..
Ямар гоё вэ ! Одоо охин хүү хоёр хоёулаа нэг нэг бөмбөгтэй боллоо.

Procédure = ……………

## II- Доорхи үгсийг тохирох зурагтай нь холбоно уу





байшин бөмбөг хүү
мод охин сар





……../ 5

## III- Асуулт болгонд зөв хариултыг тойруулж зурна уу

1) Хүүхдүүд юу хийж байна ?

*Тэд дуулж байна.*

*Тэд тоглож байна.*

*Тэд ажиллаж байна.*



2) Хаана тоглож байна ?

*Гэртээ.*

*Сургуулийн коридорт.*

*Гэрийнхээ урд.*

3) Бөмбөг ямар өнгөтэй вэ ?

*Улаан.*

*Улаан хөх.*

*Улаан цагаан*

…. / 3 + …. / 3 = …. / 6

4) Зохиолын төгсгөлд яагаад хоёр бөмбөг гарч ирсэн бэ ?

*Учир нь хүүхдүүд гэртээ хоёрдох бөмбөг олсон.*

*Учир нь нар тэнгэрээс унасан.*

*Учир нь сар тэнгэрээс унасан.*

5) Энэ түүх яаж төгссөн бэ ?

*Хүүхдүүд хоорондоо эвлэрсэн.*

*Хүүхдүүд маргалдсан хэвээрээ.*

*Хүүхдүүд бөмбөгөөр тоглохоо болисон.*

6) Чиний бодлоор бол, энэ түүх үнэнээсээ тохиолдох уу ?

*Тийм*

*Үгүй*

*Мэдэхгүй.*

…. / 3 + …. / 3 + …. / 3 = …. / 9

Traduit par Erdenechimeg Rentsendorj, 15 sept. 06